


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3621 СЯА АМ.ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
11.3%



НИЙТ ХАДГАЛАМЖ
16.0 ИХ НАЯД ТӨГ



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
30.8 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
928.1 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
8%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **2.1%**,
Инфляци: 2020 онд: **6.6%**,
Урсгал тэнцэл: 2020 онд: **-13%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны 4-р сарын тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>


ДНБ-ий өсөлт: 2020 онд: **-1%**
Инфляци: 2020 онд: **5.6%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: **-10.2%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 8-р сарын байдлаар (2656) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 17.1 хувиар буурсан бол, зарлага 32.1 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2656 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 397 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 12.6 төгрөгөөр өсөв.

Наймдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 178.56 төгрөг буюу 6.7 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 12.6 төгрөг буюу 0.45 хувиар, өмнөх улирлаас 1.85 хувиар өсч 2,849.10 төгрөг болов. 7-р сард гадаад валютын нөөц 3.62 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 2 хувиар өсч, оны эхнээс 17 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 2.1%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 8-р сарын байдлаар өмнөх сараас 1 хувиар хасагдаж, өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар, оны эхнээс 2.3 хувь өсөв. Инфляцын түвшин 2017 оны 8 дугаар сард 5.0 хувь, 2018 оны 8 дугаар сард 6.0 хувь, 2019 оны 8 дугаар сард 8.9 хувь гарч байсан бол 2020 оны 8 дугаар сард 2.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 6.8 пунктээр буурсан байна.




Гадаад худалдааны тэнцэл 1026 сая.ам долларын ашигтай гарав.

2020 оны наймдугаар сард нийт барааны эргэлт 7932 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 16.8, импорт өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 1026 сая ам.долларын ашигтай гарав.



8-Р САРЫН ОНЦЛОХ: МУ-ЫН ГАДААД ӨР

Эх сурвалж: www.mongolbank.mn

2020 оны хоёрдугаар улирлын байдлаар Засгийн газрын нийт гадаад өр 7.8 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 30.8 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас 3Г-ын өр 9% (655,3 сая ам.доллар)-иар өссөн бол, Улсын нийт гадаад өр 1% (352,8 сая ам.доллар)-иар өссөн байна. Харин төв банкны өр 6% буюу 110 сая ам.доллараар өссөн бол хадгаламжийн байгууллагуудын өр 23% буюу 509,5 сая ам.доллараар буурчээ. Нийт гадаад өрийн 26%-ийг засгийн газрын өр, 7%-ийг Төв банкны өр, 6%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 26%-ийг бусад салбаруудын өр, 36%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

- Монголбанк эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан ипотекийн зээлийн хөтөлбөрт дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:
 - Орон сууцны ипотекийн 8 болон 5 хувийн хүүтэй зээл авсан иргэд энэ оны 4 дүгээр сард багтаан тухайн харилцагч банкандаа хүсэлт гаргасан тохиолдолд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа 6 хүртэлх сараар хойшлуулах боломжтой болсон.
 - Харилцагчдын хүсэлтийн дагуу зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулсан. Энэ зохицуулалтад нийт 38 мянга 270 зээлдэгчийн 2 их наяд төгрөгийн зээлийг хамруулаад байна.
 - Мөн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулаагүй харилцагчдын хувьд 2 хувийн зээлийн хүүгийн татаасыг 3 сарын хугацаанд олгохоор болсон. Үүнд 34 мянга 358 зээлдэгчийн 1.4 орчим их наяд төгрөгийн зээл хамрагдаж байна.

ЗЭЭЛИЙН ХҮҮГ 4 НЭГЖЭЭР БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨР БАТЛАГДАВ.

- Монголбанкнаас зээлийн хүүг 4 нэгжээр бууруулах хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар дэмжив. "Банкны зээлийн хүүгийн 60 орчим хувь нь эх үүсвэрийн хүү, 17 орчим хувь нь банкны үйл ажиллагааны зардал, 11 хувь нь зээлийн эрсдэлтэй холбоотой зардал, үлдсэн нь банкуудын өрсөлдөөн, төвлөрөлтэй холбоотой зардал зарцуулагдаж байна. Манай улсад үйл ажиллагаа явуулж буй 12 арилжааны банкны 11 нь хувийн, нэг нь төрийн мэдлийн банк байдаг.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 8-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 8-р сар 2020 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn